



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/10/НА-СТА-ОНА

| | |
|--|--|
| Цахим хуудас: www.audit.mn | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: Altantuya.m@audit.gov.mn |
| Баянхонгор 2024 оны 03 дугаар сарын 20 | |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр) | 4 |
| 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан (төгрөгөөр) | 4 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)..... | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр) | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 7 |
| 3.1 Компанийн /ОНӨААТҮГ/, түүний үйл ажиллагаа | 7 |
| 3.2 Компанийн /ОНӨААТҮГ/ гадаад, дотоод орчин..... | 8 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 8 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгад гарсан өөрчлөлтүүд..... | 9 |
| 4. Аудитын тайлан | 11 |
| 4.1 Ерөнхий зүйл | 11 |
| 4.2 Материаллаг байдал | 12 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 12 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 12 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 13 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 13 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 13 |
| 5. Аудитын илрүүлэлт | 13 |
| 5.1 Албан шаардлага | 13 |
| 5.2 Зөвлөмж..... | 13 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЦТХХК | Цахилгаан түгээх хариуцлагатай компани |
| ДҮТ | Диспичерийн үндэсний төв |



БЯАНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ ЦТ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.УЛАМБАЯР ТАНАА

**БЯАНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 2/87

танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрчим хүч ЦТХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрчим хүч ЦТХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023.01.23-ны өдрийн 86 дугаар тогтоолоор “ДҮТ” ТӨХХК-аас худалдан авах цахилгааны тарифыг 157.47 төгрөг, түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг 303,468.3 мянган төгрөг, 2023.11.22 -ны өдрийн 649 дүгээр тогтоолоор “ДҮТ” ТӨХХК-аас худалдан авах цахилгааны тарифыг 151.6 төгрөг, түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг 462,269.8 мянган төгрөг болгон өөрчлөн баталсан байна..

Бусад асуудлын хэсэг

Нийт зардал 14,419,562.9 мянган төгрөг баталж, 14,054,558.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан ба цалин, урамшуулал 92,970.4 мянга, Ажиллагсдын нийгмийн зардал 93,305.0 мянга, Албан томилолтын зардал 10,169.7 мянга, шатахуун, харилцаа холбоо, харуул хамгаалалтын зардал 5,290.3- 6,765.5

5020327

мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Бусад татвар хураамжийн зардал 25,289.8 мянган төгрөгийг төлөвлөж батлаагүй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 17 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 484,913.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Үлдэгдэл | |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| А | Б | 1 | 2 |
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 49,240,603.18 | 491,516,844.40 |
| 1.1.2 | Дансны авлага | 1,159,818,927.74 | 1,188,603,601.17 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 0.00 | 0.03 |
| 1.1.4 | Бусад авлага | 117,353,207.01 | 65,087,153.01 |
| 1.1.6 | Бараа материал | 394,208,050.25 | 1,430,371,627.57 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 126,692,280.16 | 406,066,612.57 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 1,847,313,068.35 | 3,581,645,838.75 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 18,637,580,197.30 | 19,926,702,789.38 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 460,904,475.83 | 447,308,560.75 |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 615,454,398.00 | - |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 19,713,939,071.43 | 20,374,011,350.13 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 21,561,252,139.46 | 23,955,657,188.88 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 419,726,110.73 | 90,161,847.43 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0.00 | 0.10 |
| 2.1.1.3 | Татварын өр | 154,037,984.28 | 99,199,490.06 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 23.47 | 85.77 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 17,873,770.42 | 11,242,174.76 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | - | (0.01) |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 591,637,888.90 | 200,603,598.13 |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 509,040,998.95 | 468,461,713.99 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 509,040,998.95 | 468,461,713.99 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 1,100,678,887.85 | 669,065,312.12 |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 1,426,737,382.97 | 1,426,737,382.97 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 5,027,341,582.02 | 5,027,341,582.02 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 16,125,737,100.71 | 18,673,854,879.36 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (2,119,242,814.09) | (1,841,341,967.95) |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 20,460,573,251.61 | 23,286,591,876.40 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 21,561,252,139.46 | 23,955,657,188.51 |

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---------------|--|-------------------|--------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 12,377,877,436.16 | 13,842,895,405.95 |
| 2 | Борлуулалтын өртөг | 8,569,229,813.15 | 9,313,740,723.73 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 3,808,647,623.01 | 4,529,154,682.22 |
| 5 | Хүүний орлого | 95,454.54 | 1,299,270.29 |
| 8 | Бусад орлого | 673,617,362.56 | 519,142,407.42 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 701,211,490.36 | 893,798,073.02 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 2,963,136,615.43 | 3,415,862,132.04 |
| 11 | Санхүүгийн зардал | 10,219,617.98 | 5,202,688.10 |
| 12 | Бусад зардал | 557,498,126.21 | 420,031,747.95 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (3,203,791.33) | (5,923,000.89) |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 247,090,798.81 | 308,778,717.92 |

| | | | |
|----|-------------------------------------|----------------|----------------|
| 19 | Орлогын татварын зардал | 24,709,079.89 | 30,877,871.79 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 222,381,718.92 | 277,900,846.13 |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 222,381,718.92 | 277,900,846.13 |
| 24 | Орлогын нийт дүн | 222,381,718.92 | 277,900,846.13 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт дүн |
|--|-------------------------|-------------------------------------|---------------------------|-------------------------------|--------------------------|
| 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 1,426,737,382.97 | 5,027,341,582.02 | 16,116,347,100.71 | (2,341,624,533.06) | 20,228,801,532.64 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.05 | 0.05 |
| Залруулсан үлдэгдэл | 1,426,737,382.97 | 5,027,341,582.02 | 16,116,347,100.71 | (2,341,624,533.01) | 20,228,801,532.69 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 222,381,718.92 | 222,381,718.92 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 9,390,000.00 | 0.00 | 9,390,000.00 |
| 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 1,426,737,382.97 | 5,027,341,582.02 | 16,125,737,100.71 | (2,119,242,814.09) | 20,460,573,251.61 |
| Залруулсан үлдэгдэл | 1,426,737,382.97 | 5,027,341,582.02 | 16,125,737,100.71 | (2,119,242,814.09) | 20,460,573,251.61 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 277,900,846.13 | 277,900,846.13 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 2,548,117,778.65 | 0.00 | 2,548,117,778.65 |
| 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 1,426,737,382.97 | 5,027,341,582.02 | 18,673,854,879.36 | (1,841,341,967.95) | 23,286,591,876.40 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 11,197,804,569.30 | 12,308,501,265.78 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 8,281,490,951.34 | 11,724,481,700.99 |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | 671,061.60 |
| | Татаас, санхүүжилтийн орлого | - | 110,000.00 |
| | Бусад мөнгөн орлого | 2,916,313,617.96 | 583,238,503.19 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 11,276,062,281.40 | 11,854,011,896.38 |
| | Ажиллагчдад төлсөн | 1,278,167,465.97 | 1,657,293,170.25 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 444,073,866.93 | 558,454,608.32 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 4,790,469,787.32 | 784,631,500.00 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 100,600,681.42 | 108,889,596.22 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 57,602,458.00 | 72,337,385.00 |
| | Хүүний төлбөрт төлсөн | - | 2,375,292.43 |
| | Татварын байгууллагад төлсөн | 263,270,666.41 | 530,208,552.10 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 4,759,040.00 | 53,423,788.58 |
| | Бусад мөнгөн зарлага | 4,337,118,315.35 | 8,086,398,003.48 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (78,257,712.10) | 454,489,369.40 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 4,350,000.00 | 6,408,250.70 |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 4,350,000.00 | - |

| | | | |
|-----|---|-------------------------|------------------------|
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | 6,000,000.00 |
| | Хүлээн авсан хүүний орлого | - | 408,250.70 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 336,935,108.21 | 18,621,378.88 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 308,877,608.21 | 18,621,378.88 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 28,057,500.00 | - |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (332,585,108.21) | (12,213,128.18) |
| 4.2 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (410,842,820.31) | 442,276,241.22 |
| 5.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 460,083,423.49 | 49,240,603.18 |
| 5.2 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 49,240,603.18 | 491,516,844.40 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Зардлын төрөл | Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл | Тайлант оны | | Зөрүү |
|----|--------------------------------------|-------------------------------|-------------------------|-------------------------|-----------------------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 0 | ХАЦЭХ | 8,569,229,813.15 | 9,747,145,932.30 | 9,313,740,723.72 | 433,405,208.58 |
| 1 | Шатахууны зардал | 38,579,017.08 | 45,508,100.00 | 38,742,573.56 | 6,765,526.44 |
| 3 | Сэлбэг хэрэгсэл | 38,667,670.66 | 39,129,000.00 | 34,721,155.99 | 4,407,844.01 |
| 4 | Урсгал засвар | 87,083,690.90 | 118,865,000.00 | 118,877,765.87 | 12,765.87 |
| 6 | Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал | 1,526,402,660.85 | 1,996,858,312.00 | 1,903,887,910.09 | 92,970,401.91 |
| 7 | Байгууллагаас төлөх ЭМ, НДШ | 230,549,840.57 | 289,544,500.00 | 287,633,659.79 | 1,910,840.21 |
| 8 | Ашиглалтын зардал-Цахилгаан | 12,698,550.84 | 14,023,170.00 | 13,745,585.84 | 277,584.16 |
| 9 | Ашиглалтын зардал-Дулаан | 93,128,565.46 | 105,937,558.10 | 102,704,562.43 | 3,232,995.67 |
| 10 | Ашиглалтын зардал-Ус | 4,846,778.16 | 4,479,680.90 | 4,408,265.44 | 71,415.46 |
| 11 | Албан томилолтын зардал | 8,166,245.30 | 24,896,000.00 | 14,726,334.00 | 10,169,666.00 |
| 12 | Конторын хангамжийн зардал | 3,572,560.91 | 4,246,300.00 | 4,366,328.17 | 120,028.17 |
| 13 | Харилцаа холбооны зардал | 5,293,597.19 | 11,171,196.00 | 4,755,110.91 | 6,416,085.09 |
| 14 | Харуул хамгаалалтын зардал | 23,881,909.10 | 42,000,000.00 | 36,709,707.27 | 5,290,292.73 |
| 15 | Хөдөлмөр хамгааллын зардал | 40,379,847.23 | 61,837,830.00 | 54,315,744.21 | 7,522,085.79 |
| 16 | Даатгалын зардал | 13,580,550.00 | 13,516,190.00 | 13,538,775.00 | 22,585.00 |
| 18 | Гүйцэтгэх удирдлагын зардал | 215,808,644.42 | 280,556,000.00 | 280,555,648.72 | 351.28 |
| 19 | Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал | 42,620,436.94 | 45,056,400.00 | 43,780,475.49 | 1,275,924.51 |
| 21 | Борлуулалт, маркетингийн зардал | 7,970,056.24 | 6,506,720.00 | 5,426,517.39 | 1,080,202.61 |
| 23 | Зохицуулалтын үйлчилгээний хөлс | 9,300,000.00 | 11,648,200.00 | 11,800,000.00 | 151,800.00 |
| 24 | Гадны үйлчилгээний хөлс | 18,247,052.96 | 33,610,100.00 | 33,609,878.14 | 221.86 |


| | | | | | |
|---|--|--------------------------|--------------------------|--------------------------|-----------------------------|
| 26 | Сургалтын зардал | 21,396,346.00 | 8,752,400.00 | 8,570,580.27 | 181,819.73 |
| 28 | Үйл ажиллагааны бусад зардал | 1,317,931.20 | 1,242,200.00 | 1,170,069.26 | 72,130.74 |
| Үйл ажиллагааны зардлын дүн | | 2,449,434,175.79 | 3,159,384,845.30 | 3,018,046,647.84 | 141,338,197.46 |
| 30 | Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 197,028,468.52 | 219,711,200.00 | 216,865,525.80 | 2,845,674.20 |
| 31 | Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 821,811,284.32 | 719,908,300.00 | 862,898,714.87 | - 142,990,414.87 |
| Элэгдлийн зардлын дүн | | 1,018,839,752.84 | 939,619,500.00 | 1,079,764,240.67 | 140,144,740.67 |
| 32 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | 9,491,826.52 | 14,836,974.00 | 20,726,858.32 | - 5,889,884.32 |
| 33 | АТӨЯХ-ийн албан татвар | 877,486.00 | 866,600.00 | 906,806.00 | - 40,206.00 |
| 34 | Газрын төлбөр | 869,136.50 | 1,234,900.00 | 1,234,784.00 | 116.00 |
| 35 | Бусад татвар хураамж | 2,021,919.50 | | 25,289,791.06 | - 25,289,791.06 |
| Орлогын албан татвараас бусад татварын дүн | | 13,260,368.52 | 16,938,474.00 | 48,158,239.38 | 31,219,765.38 |
| 37 | Ажиллагсдын нийгмийн зардал | 192,305,637.10 | 277,558,031.10 | 184,253,055.46 | 93,304,975.64 |
| Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн | | 202,525,255.08 | 282,760,719.20 | 189,455,743.56 | 93,304,975.64 |
| 38 | Үйл ажиллагааны бус зардал | 555,164,636.49 | 273,713,400.00 | 405,392,743.60 | - 131,679,343.60 |
| НИЙТ ЗАРДАЛ /29+32+37+41+42+43/ | | 12,808,454,001.87 | 14,419,562,870.80 | 14,054,558,338.77 | 365,004,532.03 |
| 40 | Борлуулалтын орлого | 9,761,438,236.17 | 10,152,171,670.80 | 9,883,672,605.95 | 268,499,064.85 |
| 41 | Түгээх үйлчилгээ орлого | 2,616,449,200.00 | 3,993,677,800.00 | 3,959,222,800.00 | 34,455,000.00 |
| 42 | Бусад орлого | 677,667,319.97 | 273,713,400.00 | 520,441,644.92 | - 246,728,244.92 |
| НИЙТ ОРЛОГО /46+47-45/ | | 13,055,544,756.14 | 14,419,562,870.80 | 14,363,337,050.87 | 56,225,819.93 |
| 43 | ТАТВАРЫН ДАРААХ АШИГ/АЛДАГДАЛ | 222,381,678.84 | 0.03 | 277,900,840.89 | - 277,900,840.92 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн /ОНӨААТҮГ/, түүний үйл ажиллагаа

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн зорилго нь “Стандартын цахилгаан эрчим хүчээр хангах, түгээх, борлуулах үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж сүлжээний алдагдлыг багасган хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж, мэргэшсэн чадварлаг боловсон хүчнээр соёлтой, чанартай үйлчилгээг үзүүлж, шударга харилцааг эрхэмлэн ажиллах”-д оршино.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Эрдэнэт, Булган, Хархорин Өвөрхангай аймгийн 110кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүч дамжуулан авч хэрэглэгчдэд түгээх” гэж тодорхойлжээ.



Тус газар нь цахилгаан шугам сүлжээ шуурхай үйлчилгээний алба, хэрэглэгчдэд үйлчлэх төв, захиргаа аж ахуйн гэсэн 3 алба хэсэгтэй, 94 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах нэгдүгээр гарын Захирал Ж.Уламбаяр, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Б.Хорлоо, нягтлан бодогч О.Ууганбаяр нар зурж нярваар Ш.Ундармаа нар ажилласан байна.

3.2 Компанийн /ОНӨААТҮГ/ гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Аймгийн Засаг Даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт “Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг хэрэгцээ шаардлагын дагуу нэмэгдүүлж гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станц шинээр байгуулан албан байгууллага, айл өрхүүдийг шөнийн тарифт, ухаалаг тоолуурт шилжүүлэх” тухай заалт тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023.01.23-ны өдрийн 86 дугаар тогтоолоор “ДҮТ” ТӨХХК-аас худалдан авах цахилгааны тарифыг 157.47 төгрөг, түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг 303,468.3 мянган төгрөг, 2023.11.22 -ны өдрийн 649 дүгээр тогтоолоор “ДҮТ” ТӨХХК-аас худалдан авах цахилгааны тарифыг 151.6 төгрөг, түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг 462,269.8 мянган төгрөг болгон өөрчлөн баталсан байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын бүтцэд дотоод хяналтын ажилтан гүйцэтгэх удирдлагын шууд удирдлагад ажиллаж байгаа ба дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулан ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа 2018 нд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч Татвар, Нийгмийн даатгал, Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлт, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах шаардлагатай байна.



3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгад гарсан өөрчлөлтүүд

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 23,955,657.1 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 2,394,405.0 мянган төгрөгөөр буюу 11 хувиар хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|---------------------|---------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 49,240.6 | 491,516.8 | 442,276.2 |
| Авлага | 1,277,172.1 | 1,253,690.7 | (23,481.4) |
| Бараа материал | 394,208.05 | 1,430,371.6 | 1,036,163.6 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 126,692.2 | 406,066.6 | 279,374.3 |
| Үндсэн хөрөнгө | 19,253,034.6 | 19,926,702.7 | 673,668.1 |
| Биет бус хөрөнгө | 460,904.4 | 447,308.5 | (13,595.9) |
| Нийт хөрөнгө | 21,561,252.1 | 23,955,657.1 | 2,394,405 |
| Богино хугацаат өр төлбөр | 591,637.9 | 200,603.5 | (391,034.3) |
| Урт хугацаат өр төлбөр | 509,040.9 | 468,461.7 | (40,579.3) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 20,460,573.2 | 23,286,591.8 | 2,826,018.6 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 21,561,252.1 | 23,955,657.1 | 2,394,405 |

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 491,516.8 мянган төгрөг болж 442,276.2 мянган төгрөгөөр өссөн нь тарифын үнэ буурсан, түгээх үйлчилгээний орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 1,253,690.7 мянган төгрөг болж 23,481.4 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнээс цахилгаан үйлчилгээтэй авлага 1,188,603.6 мянга, холбоотой талуудын авлага 65,087.2 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Цахилгаа үйлчилгээний авлагын дэлгэрэнгүй /мянган төгрөг/

| Цахилгаа үйлчилгээний авлага | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------------------------|--------------------|--------------------|
| Цахилгааны авлага-ахуй | 2,838.6 | 303.0 |
| Цахилгааны авлага-алба | 29,534.5 | 41,140.4 |
| Шөнийн тарифын авлага | 191,526.3 | 141,323.4 |
| Нэхэмжлэгдээгүй авлага | 957,125.0 | 1,027,042.4 |
| Найдваргүй авлагын хасагдуулаг | (21,205.5) | (21,205.5) |
| ДҮН | 1,159,818.9 | 1,188,603.6 |

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн тайлангийн тодруулга тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 406,066.6 мянган төгрөг болж 279,374.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь шинэ суурьшлын бүсийн шинэ дэд станц, агаарын шугамтай холбоотой дуусаагүй 380,856.8 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,430,371.7 мянган төгрөг болж 1,036,163.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.12.05-ны өдрийн 17/64 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шинэ суурьшлын бүсийг цахилгаан хангамжид холбох ажилд шаардагдах 37 нэр төрлийн 1,195,000.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй бүртгэж авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19,926,702.7 мянган төгрөг болж 673,668.1 мянган төгрөгөөр өссөн нь 2023 онд барилга байгууламжид их засвар, техник зохион байгуулалт,

хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд өөрийн хөрөнгөөр 36 нэр төрлийн үндсэн хөрөнгөд капиталжуулалт сайжруулалтыг 173,392.4 мянган төгрөг, 8 нэр төрлийн 641,075.4 мянган төгрөгийн өртөг бүхий дэд станц, ЦДАШ ,трансформатор барьж ашиглалтад оруулсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 4 удаагийн тогтоолоор улсын аймаг, сумын ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн 1,246,646.6 мянган төгрөгийн дэд станц, шугам сүлжээ, гэрэлтүүлгийн ажлыг үнэ төлбөргүй нь орлогоор бүртгэж, 17,957.1 мянган төгрөгийн хөрөнгийн акталж данс бүртгэлээс хассан байна.

Дуусаагүй барилга дансанд байсан 615,454.4 мянган төгрөгийн өндөр хүчдэлийн туршилт тохируулгын лабораторийн барилгыг барилга дансанд шилжүүлэн бүртгэсэн.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 391,034.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд: Диспетчерийн Үндэсний Төв ХХК-д худалдан авсан цахилгааны өглөг 16,717.6 мянга, МҮОНТВ-ийн өглөг 6,406.9 мянга, 67,037.3 мянган төгрөг нь хог тээврийн хураамжийн төлбөр байна. Татварын өглөг 99,199.5 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 54,838.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 468,461.7 мянган төгрөг болж 40,579.3 мянган төгрөгийн зээлийн төлбөр төлөгдсөн байна. Зээлийн хүүгийн төлбөр 5,202.7 мянган төгрөгийг хүүгийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэн шилжүүлсэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 23,286,591.8 мянган төгрөг болж 2,826,018.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 277,900.8 мянган төгрөгөөр өсөж 2,548,117.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч эздийн өмчийг нэмэгдүүлсэн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө/ техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023.02.08-ны өдрийн 02 дугаар тогтоолоор тус компанийн 2023 оны орлого, зарлагын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 14,067,504.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 14,067,504.3 мянган төгрөгөөр нийт ашиг алдагдлыг 0 төгрөг баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 646,843.4 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 14,363,337.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 14,054,558.3 мянган төгрөгийн зардал гаргаж 277,900.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зорилтот түвшний гүйцэтгэлээр нийт орлого 14,363,337.1 мянган төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Үүнд борлуулалтын орлогыг 10,152,171.7 мянган төгрөг оруулахаар төлөвлөснөөс 9,883,672.6 мянган төгрөг, түгээх үйлчилгээний орлогыг 3,993,677.8 мянган төгрөгөөс 3,959,222.8 мянган төгрөг, бусад орлого 273,713.4 мянган төгрөг оруулахаас 520,441.6 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нийт зардал 14,419,562.9 мянган төгрөг баталж, 14,054,558.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан ба цалин, урамшуулал 92,970.4 мянга, Ажиллагсдын нийгмийн зардал 93,305.0 мянга, Албан томилолтын зардал 10,169.7 мянга, шатахуун, харилцаа холбоо, харуул хамгаалалтын зардал 5,290.3- 6,765.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Бусад татвар хураамжийн зардал 25,289.8 мянган төгрөгийг төлөвлөж батлаагүй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 17 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 484,913.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 2. 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин



(мянган төгрөг)

| № | Зардлын төрөл | Өмнөх оны мө үеийн гүйцэтгэл | Тайлант оны | | |
|----|--|---------------------------------|---------------------|---------------------|--------------------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| 0 | ХАЦЭХ | 8,569,229.8 | 9,747,145.9 | 9,313,740.7 | 433,405.2 |
| 1 | Шатахууны зардал | 38,579.0 | 45,508.1 | 38,742.6 | 6,765.5 |
| 3 | Сэлбэг хэрэгсэл | 38,667.7 | 39,129.0 | 34,721.2 | 4,407.8 |
| 4 | Урсгал засвар | 87,083.7 | 118,865.0 | 118,877.8 | - 12.8 |
| 6 | Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал | 1,526,402.7 | 1,996,858.3 | 1,903,887.9 | 92,970.4 |
| 7 | Байгууллагаас төлөх ЭМ, НДШ | 230,549.8 | 289,544.5 | 287,633.7 | 1,910.8 |
| 8 | Ашиглалтын зардал- Цахилгаан | 12,698.6 | 14,023.2 | 13,745.6 | 277.6 |
| 9 | Ашиглалтын зардал-Дулаан | 93,128.6 | 105,937.6 | 102,704.6 | 3,233.0 |
| 10 | Ашиглалтын зардал-Ус | 4,846.8 | 4,479.7 | 4,408.3 | 71.4 |
| 11 | Албан томилолтын зардал | 8,166.2 | 24,896.0 | 14,726.3 | 10,169.7 |
| 12 | Конторын хангамжийн зардал | 3,572.6 | 4,246.3 | 4,366.3 | - 120.0 |
| 13 | Харилцаа холбооны зардал | 5,293.6 | 11,171.2 | 4,755.1 | 6,416.1 |
| 14 | Харуул хамгаалалтын зардал | 23,881.9 | 42,000.0 | 36,709.7 | 5,290.3 |
| 15 | Хөдөлмөр хамгааллын зардал | 40,379.8 | 61,837.8 | 54,315.7 | 7,522.1 |
| 16 | Даатгалын зардал | 13,580.6 | 13,516.2 | 13,538.8 | - 22.6 |
| 18 | Гүйцэтгэх удирдлагын зардал | 215,808.6 | 280,556.0 | 280,555.6 | 0.4 |
| 19 | Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал | 42,620.4 | 45,056.4 | 43,780.5 | 1,275.9 |
| 21 | Борлуулалт, маркетингийн зардал | 7,970.1 | 6,506.7 | 5,426.5 | 1,080.2 |
| 23 | Зохицуулалтын үйлчилгээний хөлс | 9,300.0 | 11,648.2 | 11,800.0 | - 151.8 |
| 24 | Гадны үйлчилгээний хөлс | 18,247.1 | 33,610.1 | 33,609.9 | 0.2 |
| 26 | Сургалтын зардал | 21,396.3 | 8,752.4 | 8,570.6 | 181.8 |
| 28 | Үйл ажиллагааны бусад зардал | 1,317.9 | 1,242.2 | 1,170.1 | 72.1 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 2,449,434.2 | 3,159,384.8 | 3,018,046.6 | 141,338.2 |
| 30 | Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 197,028.5 | 219,711.2 | 216,865.5 | 2,845.7 |
| 31 | Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 821,811.3 | 719,908.3 | 862,898.7 | - 142,990.4 |
| | Элэгдлийн зардлын дүн | 1,018,839.8 | 939,619.5 | 1,079,764.2 | - 140,144.7 |
| 32 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | 9,491.8 | 14,837.0 | 20,726.9 | - 5,889.9 |
| 33 | АТӨЯХ-ийн албан татвар | 877.5 | 866.6 | 906.8 | - 40.2 |
| 34 | Газрын төлбөр | 869.1 | 1,234.9 | 1,234.8 | 0.1 |
| 35 | Бусад татвар хураамж | 2,021.9 | - | 25,289.8 | - 25,289.8 |
| | Орлогын албан татвараас бусад татварын дүн | 13,260.4 | 16,938.5 | 48,158.2 | - 31,219.8 |
| 37 | Ажиллагсдын нийгмийн зардал | 192,305.6 | 277,558.0 | 184,253.1 | 93,305.0 |
| | Хөрөнгө оруулалтын өгөөжөөр | 202,525.3 | 282,760.7 | 189,455.7 | 93,305.0 |
| 38 | Үйл ажиллагааны бус зардал | 555,164.6 | 273,713.4 | 405,392.7 | - 131,679.3 |
| | НИЙТ ЗАРДАЛ /29+32+37+41+42+43 | 12,808,454.0 | 14,419,562.9 | 14,054,558.3 | 365,004.5 |
| 40 | Борлуулалтын орлого | 9,761,438.2 | 10,152,171.7 | 9,883,672.6 | 268,499.1 |
| 41 | Түгээх үйлчилгээ орлого | 2,616,449.2 | 3,993,677.8 | 3,959,222.8 | 34,455.0 |
| 42 | Бусад орлого | 677,667.3 | 273,713.4 | 520,441.6 | - 246,728.2 |
| | НИЙТ ОРЛОГО /46+47-45/ | 13,055,544.8 | 14,419,562.9 | 14,363,337.1 | 56,225.8 |
| 43 | ТАТВАРЫН ДАРААХИ АШИГ/АЛДАГДАЛ | 222,381.7 | - 0.0 | 277,900.8 | - 277,900.8 |

эх сурвалж: “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2023 оны орлого, зардлын төлөвлөгөө , гүйцэтгэл

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн



тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хэрэгжүүлсэн.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 14,054,558.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 140,545.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 98,381.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 101 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулахаас 101 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Тайлант онд шатахуун, бетон тулгуурын материал нийлүүлэх, өндөр хүчдэлийн туршилт, тоолуур хэмжих хэрэгслийн лабораторийн барилга, тоноглолын материал нийлүүлэх, трансформатор нийлүүлэх 5 гэрээний 1,152,163.8 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10,869,546.2 мянган төгрөгийн 42 гүйлгээ, хүний нөөц, өмч хөрөнгө, санхүүтэй холбоотой 28 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 60,852.2 мянган төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд



Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аудитаар нийт 9,307.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 9,307.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 9,307.0 | 1 | 9,307.0 | 100 |
| Нийт дүн | 1 | 9,307.0 | 1 | 9,307.0 | 100 |

Аудитаар тогтоосон актын төлбөрийг барагдуулсан, зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар тус байгууллагын 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 165 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,800.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 12,000.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчил давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтыг гэрээг үндэслэн 4 албан хаагчдад тус бүр 3.0 сая төгрөгийг 6 сарын хугацаатай сарын 0.5 хувийн хүүтэй зээл олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилган, цаашид таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Компанийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнг 14,362,037.8 мянган төгрөгөөр тайлагнасан байхад дүн цахим татварын системийн НӨАТ-ын тайлангийн борлуулалтын дүн 14,944,644.7 мянган төгрөг буюу 582.606.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Компани нь цахилгааны борлуулалтыг мөнгөөр орж ирэх үед нь НӨАТ-ын борлуулалтаар тайлагнадаг, зарим нэг төсөвт байгууллагад цахилгааны төлбөрийн нэхэмжлэхээр болон төлбөрийн баримтаар борлуулалтыг давхардуулан бичсэн зэрэг нь зөрүү үүсэн нөхцөл болсон байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.1.бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд; 10.3.Цахилгаан, дулаан, хий, усан хангамж, шуудан, харилцаа холбооны болон бусад тогтмол үйлчилгээнд албан татвар ногдуулах хугацааг төлбөрийн баримт үйлдсэн буюу



төлбөрийг хүлээн авсан өдрийн аль түрүүнд хийгдсэнээр нь тогтооно.гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: 2023 оны санхүүгийн тайлангаар хүлээн зөвшөөрсөн борлуулалтыг цахим татварын системийн НӨАТ-ын борлуулалттай тулган баталгаажуулалт хийж зөрүүг арилгах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор , шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|----------|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтыг гэрээг үндэслэн 4 албан хаагчдад тус бүр 3.0 сая төгрөгийг 6 сарын хугацаатай сарын 0.5 хувийн хүүтэй зээл олгосон. | 1 | 12,000.0 | | | 1 | 12,000.0 | | |
| Компанийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнг 14,362,037.8 мянган төгрөгөөр тайлагнасан байхад дүн цахим татварын системийн НӨАТ-ын тайлангийн борлуулалтын дүн 14,944,644.7 мянган төгрөг буюу 582.606.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Компани нь цахилгааны борлуулалтыг мөнгөөр орж ирэх үед нь НӨАТ-ын борлуулалтаар тайлагнадаг, зарим нэг төсөвт байгууллагад цахилгааны төлбөрийн нэхэмжлэхээр болон төлбөрийн баримтаар борлуулалтыг давхардуулан бичсэн зэрэг нь зөрүү үүсэн нөхцөл болсон байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Нийт дүн | 2 | 12,000.0 | | | 1 | 12,000.0 | 1 | 0 |

-----oOo-----

